



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМ**



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ҮР ЧАДВАРЫГ
ДЭЭШЛҮҮЛЭХ ТӨСӨЛ



АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ

Салбар:

Барилга

Мэргэжлийн нэр:

Хуурай хийц угсрагч

Улаанбаатар хот

2018 он

Ажил мэргэжлийн лавлах: Хуурай хийц угсрагч

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн Чадамжид суурилсан сургалтын материал боловсруулах зөвлөх үйлчилгээний хүрээнд сайжруулан боловсруулав.

ISBN:

Ажил мэргэжлийн лавлахын баталгаажилт

Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолт (YAMAT 08)-ын код:	7123-14
Хөтөлбөрийн индекс: Боловсролын Олон Улсын Стандарт Ангилал (ISCED-13):	Барилга барих 0732-607
Баталсан байгууллага, огноо:	МБСУЗ-ийн 2018 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоол
Баталгаажуулсан байгууллага, огноо:	Монголын Барилгачдын Нэгдсэн Холбоо 2018 оны 03 дугаар сарын 27-ны өдөр
Хянан засварласан хувилбар, огноо	№ 01оны ... дугаар сарын ны өдөр
Хянан засварлах хугацаа	Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн тогтоож, өөрчлөлт орох эсвэл шаардлагатай тохиолдол бүрт
Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан аргачлал	ДАКУМ шинжилгээний аргачлал

Энэхүү ажил мэргэжлийн лавлахыг ХНХЯ-ны зөвшөөрөлгүйгээр олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.

АГУУЛГА

	Хуудасны дугаар
Өмнөх үг	3
Товчилсон үгийн тайлбар	4
1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ	5
2. Ажлын байрны товч тодорхойлолт	6
3. Ажлын байрны тухай мэдээлэл	6
3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл	
3.2 Ажлын байранд тавигдах шаардлага	
3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт	
3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал	
4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл	7
5. Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил	8
5.1 Мэдлэг	
5.2 Ур чадвар	
5.3 Хандлага, төлөвшил	
6. Үүрэг ба ажилбарын жагсаалт	9
7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо	10
8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл	11
9. Хуурай хийц угсрагч мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл	12

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх чиглэл хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэх, төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хэрэгжүүлж буй L3243-MON “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд “Хуурай хийц угсрагч” мэргэжлийн ажил мэргэжлийн лавлахыг боловсруулав.

Мэргэжлийн боловсрол, сургалтад оролцогч талууд төрийн байгууллага, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоод, ажил хайгч, оюутан, суралцагч зэрэг хэрэглэгчдийн нийтлэг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн энэхүү ажил мэргэжлийн лавлахыг боловсруулсан бөгөөд лавлахыг хэн хэрхэн ямар хэрэгцээнд зориулан ашиглаж болохыг дараах байдлаар тусгасан. Үүнд:

- төрийн байгууллага хөдөлмөр эрхлэлт, техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын талаар бодлого боловсруулах, хянах, хөдөлмөрийн харилцаатай холбогдох мэдээллийг авах, ажилтны ур чадварыг үнэлэхэд;
- ажил олгогчид нь ажлын байрны тодорхойлолт, аж ахуйн нэгж байгууллагын дотоод дүрэм, журам боловсруулахад;
- политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, мэргэжлийн сургалтын байгууллага, түүнчлэн холбогдох их, дээд сургуулиуд нь сургалтын хөтөлбөрөө боловсруулах, төгсөгчдийн ур чадварын үнэлгээ хийх, багш нарыг сургаж бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэхэд;
- ажил хайгч иргэд, суралцагчид нь ажлын байрны хэрэгцээ шаардлага, түүнд шаардагдах ур чадвар, мэдлэг, хандлага төлөвшил, хөдөлмөрийн нөхцлийн талаарх мэдээллийг олж авахад ажил мэргэжлийн лавлахыг ашиглаж болно.

Ажил мэргэжлийн лавлах нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно.

Мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, хийж гүйцэтгэх үүрэг, ажилбарыг салбарын зөвлөх, мэргэжилтэн, томоохон аж ахуйн нэгж байгууллага, ажил олгогчид, мэргэжлийн холбоодын төлөөлөл, политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн багш нарын мэдлэг, туршлагад тулгуурлан ажил мэргэжлийн дүн шинжилгээний ДАКУМ арга зүйгээр боловсруулсан.

Монгол Улсын мэргэжлийн боловсрол, сургалтын салбар нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд бодитоор нийцэж, төр, хувийн хэвшлийн түншлэл, шинэ техник технологи, шинэлэг арга зүйд тулгуурлан хөгжих болтугай.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МБСБХЗГ	Мэргэжлийн боловсрол, сургалтын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АМЛ	Ажил мэргэжлийн лавлах
АМДШ	Ажил мэргэжлийн дүн шинжилгээ
АХБ	Азийн хөгжлийн банк
БАЗТ	Бүсийн арга зүйн төв
МБС	Мэргэжлийн боловсрол, сургалт
МБСБ	Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага
МБСҮЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын Үндэсний зөвлөл
МБССЗ	Мэргэжлийн боловсрол сургалтын салбар зөвлөл
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ҮМХ	Үндэсний мэргэшлийн хүрээ
ХЭУЧД төсөл	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл

1. Ажил мэргэжлийн лавлахын хэрэглээ

Энэхүү ажил мэргэжлийн лавлах нь ажлын байранд тавигдах шаардлага, мөрдөж ажиллах стандарт, ашиглах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ажилтны эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлагаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчдын талаарх ерөнхий мэдээллийг агуулсан болно. Уг лавлагаас дараах хэрэглэгчид шаардлагатай мэдээллийг олж авна. Үүнд:

Хэрэглэгч	Лавлагаас авах мэдээлэл
Төрийн байгууллага	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үндэсний болон салбар, бүс, орон нутгийн түвшинд тодорхойлж боловсруулах; • Мэргэжлийн боловсрол, сургалтын стандарт боловсруулах, ажлын байр, хөдөлмөрийн харилцааг зохицуулах асуудалтай холбогдох мэдээллийг авах; • Ажил олгогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэй ажилтны ур чадварыг үнэлэх; • Иргэдэд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх зорилгоор ашиглах.
Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон Политехник коллеж	<ul style="list-style-type: none"> • Ажил олгогчийн шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах; • Тухайн мэргэжлийн чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, багшийг сургаж бэлтгэх; • Суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх; • Ажил олгогч, аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллах, үйлдвэрлэлийн дадлагыг хамтран зохион байгуулах.
Ажил олгогч	<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны тодорхойлолт, ажилтан сонгон шалгаруулах шалгуурыг боловсруулах; • Ажилтныг үнэлэх, үйл ажиллагааны гүйцэтгэлийн түвшинг үнэлэх, цалинг тогтоох; • Ажлын ачаалал, нормыг тогтоох; • Ажилтныг давтан сургах, мэргэшүүлэхтэй холбогдсон сургалтын хэрэгцээг тодорхойлох, захиалгат сургалтыг төлөвлөх; • Сургалтын байгууллагатай хамтран ажиллах; • Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага дээрх дадлагажуулах сургалтыг зохион байгуулах.
Иргэн ба ажил хайгч	<ul style="list-style-type: none"> • Ажлын байрны нөхцөл, тавигдаж буй шаардлагын талаар мэдээлэл авах; • Ажлын байранд гүйцэтгэх үндсэн үүрэг, ажилбар, ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн талаар мэдээлэл авах; • Мэргэжлийнхээ хүрээнд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийн талаар ойлголт авах; • Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухай мэдээлэл авах; • Ажлын байр, аж ахуйн нэгж байгууллагын талаар мэдээлэл авах.

2. Ажлын байрны товч тодорхойлолт

Хуурай хийц угсрагч нь шинэ барилгын угсралт, хуучин барилгын шинэчлэл, өргөтгөл, засварыг гүйцэтгэх хүрээнд ажлын даалгавар, техникийн зураг төслийн дагуу ажлын гадаргуу болон үндсэн хийц эдлэл эмжээр хүрээг бэлтгэх, дулаан, чийг, дууны тусгаарлалт хийх, гипсэн хавтанг ажлын байранд зөөж авчрах, хэмжээсийн дагуу зүсэх, бэхлэх зэрэг ажлуудыг багаж, тоног төхөөрөмж ашиглан гүйцэтгэнэ.

3. Ажлын байрны тухай мэдээлэл

3.1 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл

- Хуурай хийц угсрагч нь барилга, байгууламжийн талбайд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг бүрэн хангасан орчин нөхцөлд ажиллана.
- Хуурай хийц угсрагч нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдаж мэдлэг, дадлагатай болсон байна.
- Барилгын ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, стандарт, тогтоосон норм, нормативын дагуу явуулна.
- Машин механизм, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны шаардлага, зааварчилгаа болон ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангасан нөхцөлд ажиллана.
- Хуурай хийц угсрагч нь үйлдвэрлэл, ажил үйлчилгээтэй холбоотой, зайлшгүй шаардлагатай эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт хамрагдана.
- Хуурай хийц угсрагч нь хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлд ажиллах бөгөөд хуулийн дагуу тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоолгох боломжтой.

3.2 Ажлын байранд тавигдах шаардлага

- Хуурай хийц угсрагч мэргэжлийн боловсролтой, 18 нас хүрсэн иргэн байна.

3.3 Ажлын байранд шаардагдах боловсролын бичиг баримт

- Мэргэжлийн үнэмлэхтэй байна. Зарим тохиолдолд чадамжийн гэрчилгээ шаардагдаж болно.

3.4 Ажлын байранд шаардагдах машин механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, түүхий эд материал

- **Машин механизм:** Өргөх машин механизм /цамхагт кран, авто кран/, дүүжинт өргүүр, хайчин өргүүр гэх мэт.
- **Тоног төхөөрөмж:** Компрессор, өндрийн шат, суурин хөрөө, суурин таслагч, хавтан өргөх төхөөрөмж, цахилгаан гар хөрөө, цахилгаан гар фрезер, цахилгаан гар зүлгүүр, цахилгаан гар дрилл, цахилгаан гинжин цүүц, цохилттой дрилл, гагнуурын аппарат, нивелир гэх мэт.
- **Багаж хэрэгсэл:** Батарей дрилл, алх, багс, бахь, булан татагч, булан чий, зуурагч хошуу, зуурмагийн хувин, зүлгүүрийн гар, зүсэгч хутга, лазер хэмжигч, лазер тэгш ус, металл шугам, мастерийн хошуунууд, мяту, метр, отвертка, отвес, өнхрүүш, өрөвтөл, өнцөг хэмжигч, резинэн алх, пламастр, тавлагч, тасдагчийн ир, татагч, төмрийн хөрөө, төмрийн хайч, тэгш ус, үдээслэгч, үдээсний буу, үдээсний запас, халив, харуул, хайч, хавчаар, хөрөө, хуурай, цаасны хутга, цүүц, шахуургат хавчаар,

шпатель, шил зүсэгч, шрүп мастер, шрүпний буу, эвхдэг метр, эр эм булан татагч гэх мэт.

- **Түүхий эд материал:** EPS хөөсөнцөр хавтан, OSB хавтан, xps хөөсөнцөр хавтан, акустик хавтан, ам дарагч цаас, ам дарагч туузан материалууд, амьсгалдаг цаас, базальт хөвөн, банз брус /50мм х 50мм, 70мм х 50мм/, бууны шрүп, бэлэн зуурмаг, бэхлэгч, бэхэлгээний металл материалууд, гипсэн хавтан, гипсэн хүрээ, гипсний тэлэгч, ДВП /арголит/, дуу тусгаарлагч материал, замаск /гипс/, заадасны тор, зүймэл шал/паркет/, зүлгүүр, мятууны бэх, металл профилиуд, полиэтилен хальс, профиль төмөр С, профиль төмөр U, силикон, резин зөөлөвч, скоч, тавлагчийн хадаас /3мм-5мм/, тодруулагч, тастагчийн ир, төмөр булан тор, тортой булан, төмрийн шрупп, төрөл бүрийн дулаан тусгаарлагч материалууд, тусгаарлагч /шал/, тэлэгч /6мм-12мм/, туузан тор, тэлэгчтэй шрупп, ус тусгаарлагч материал, үдээс /30мм/, үзэг, харандаа, утас, уур ус тусгаарлах материал, фанер, үдээс /30мм/, хадаас /70-160 мм/, хийн бууны хадаас /30мм-50мм/, хөвөөний холбогч, холбох бэхлэх материал /дабль/, хонины ноосон дулаалга, холбогч төмрүүд, хөл төмөр, хөөсөнцөр хавтан /хана, шал, гадна фасад/, хөрсжүүлэлт, грүнт, цавуу, цемент, шилэн хөвөн, шалны хөвөө /плентус/, шахдаг хөөс, шилэн хавтан, шалны хавтан, шохой, шрүп /10мм-80 мм/, шрүп мастер, элс
- **ХАБЭА-н хэрэгсэл:** ХАБЭА-н шаардлагын дагуу анхны тусламжийн иж бүрдэл болон хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслийн бэлэн байдлыг хангана.

4. Ажлын байранд мөрдөгдөх норматив ишлэл

Ажлын байранд дараах стандарт, дүрэм журмыг баримтална. Эдгээр баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, дүрэм, журам
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- MNS 4990:2015 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд. Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага
- MNS 5080:2001 Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ
- MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
- YAMAT-08 Үндэсний ажил мэргэжлийн ангилал ба тодорхойлолт
- Ажил мэргэжлийн лавлах толь, Улаанбаатар, 2015
- БНБД 31-07-05 Дээврийн ажил
- БНБД 31-08-05 Дуу, дулаан тусгаарлалтын ажил
- БНБД 31-09-05 Шалны ажил
- БНБД 3.02.01-90 Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил
- БНБД 12-01-03 Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт

5. Хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил

5.1 Мэдлэг

- М 1. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журам
- М 2. Байгууллагын дотоод дүрэм, журам
- М 3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага
- М 4. Барилга байгууламжийн ерөнхий ойлголт
- М 5. Барилгын материал үйлдвэрлэлийн тухай ерөнхий ойлголт
- М 6. Хуурай хийц угсралтын технологийн дэс дараалал
- М 7. Ажлын багажуудын ашиглалт
- М 8. Суурийн гадаргууг бэлдэх
- М 9. Хуурай хийцийн раам бэлдэж, гипсэн хавтанг зүсэх
- М 10. Таазны суурь раам угсрах бэлдэцийг бэлтгэх
- М 11. Хуурай хийцээр хайрцаглах, далдлах
- М 12. Бэхэлгээний материалыг угсрах
- М 13. Дулаан, дуу чимээ, галын тусгаарлалт
- М 14. Хуурай хийцийг уснаас хамгаалах битүүмжлэл
- М 15. Хуурай хийцийг засварлах
- М 16. Ажлын байранд бэртэл, гэмтэл гарахад үзүүлэх эмнэлгийн анхан шатны тусламж
- М 17. Хийцүүдийн уулзварыг чигжих арга ажиллагаа
- М 18. Зөөврийн болон ачаа-хүн зөөврийн өргөгч хэрэгсэл ашиглах ерөнхий ойлголт

5.2 Ур чадвар

- УЧ 1. Ажлын болон заводын схем зургийг унших, схем дээрхи гүйцэтгэлийг төлөвлөх, гүйцэтгэх
- УЧ 2. Ажлын зураг, схемийн дагуу угсрах
- УЧ 3. Материалыг таньж мэдэх, зөөвөрлөх, хураах, хадгалах
- УЧ 4. Багаж, тоног төхөөрөмжийг ажиллуулах, цэвэрлэх, арчлах
- УЧ 5. Хуурай хийцээр өнгөлөх бэлтгэл хийх
- УЧ 6. Хуурай хийцийн ханыг засварлах
- УЧ 7. Багаж, тоног төхөөрөмж дээр хурдан дасч эзэмших

5.3 Хандлага, төлөвшил

- Х 1. Мэргэжилдээ дуртай байх
- Х 2. Багаар ажиллах чадвартай, хамтач байх
- Х 3. Бусдыг сонсдог, харилцааны соёл, ажлын байран дээрхи ёс зүйг сахидаг байх
- Х 4. Ажилдаа бүтээлчээр ханддаг, санаачлагатай байх
- Х 5. Ажлын гүйцэтгэлд логик сэтгэлгээгээр ханддаг байх
- Х 6. Ажлын хариуцлагатай байж цаг баримталдаг байх
- Х 7. Хорт зуршилгүй, хөдөлмөрийн сахилгыг мөрддөг байх
- Х 8. Хувийн зохион байгуулалт сайтай байх
- Х 9. Ажлын гүйцэтгэлд нямбай, цэгцтэй хандах

6. Үүрэг ба ажилбарын жагсаалт


Хуурай хийц угсрагчийн хийж гүйцэтгэх ажил үүргийг ажилбараар ангилан тодорхойлов. Мэргэжлийн боловсрол, сургалтаар олгох боломжгүй, дадлага ажлыг ажлын байрны бодит орчинд хийж гүйцэтгэх шаардлагатай ажилбаруудыг (*) тэмдэглэгээтэй үзүүлэв.

Д/д	Үүрэг	Ажилбар
1	Ажлын байрыг бэлтгэх	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны зааварчилгаа авах - Ажлын зурагтай танилцах - Төлөвлөгөө гаргаж материалын тооцоо хийх - Шат вандан угсрах
2	Налуу дээвэр угсрах	<ul style="list-style-type: none"> - Хэмжилтийн тэмдэглэгээ хийх - Налуу дээврийн бэлдэц угсрах - Сараалж бүтээц угсрах - Уур ус тусгаарлагч хийх - Дээврийн хучлага угсрах - Ус зайлуулагч угсрах - Дээврийн газардуулга хийх
3	Хавтгай дээвэр угсрах	<ul style="list-style-type: none"> - Хавтгай дээврийн хэмжилт хийх - Уур ус тусгаарлагч хийх - Дулаалгын материал угсрах - Дээврийн налуу гаргах - Дээвэр парпетны хавтан угсрах - Завсар зай чигжих - Хуйлмал дээвэр наах
4	Гадна дүүргэлтийн хана угсрах	<ul style="list-style-type: none"> - Дүүргэлтийн ханын хэмжилт хийх - Дүүргэлтийн бэлдэц бэлтгэх - Дүүргэлтийн ханын каркас зангидах - Уур ус дулаан тусгаарлалт хийх - Гадна дотор ханын хавтан угсрах
5	Шилэн фасад угсрах	<ul style="list-style-type: none"> - Гадаргуугын хэмжилт хийх - Холбох каркас босгох - Дулаан тусгаарлалт хийх - Шилэн хавтан угсрах - Шилэн хавтангийн заадас дулаалах - Заадасны уур ус тусгаарлалт хийх
6	Гадна ханын өнгөлгөө хийх	<ul style="list-style-type: none"> - Ханын хэмжилт хийх - Бэхэлгээний каркас угсрах - Гадна дулаалга хийх - Ус чийг тусгаарлалт хийх - Өнгөлгөөний хавтан угсрах - Заадасны чигжээс хийх
7	Гадна ханыг дулаалах	<ul style="list-style-type: none"> - Дулаалах гадаргууг хэмжих - Гадаргуугын тэгшилгээ хийх - Дулаалгын хавтан бэхлэх - Тортой шавардлага хийх - Тэгшилгээ өнгө шавардлага хийх

8	Тусгаарлах хана угсрах	<ul style="list-style-type: none"> - Ханын хэмжилт тэмдэглэгээ хийх - Хамар ханын каркас зангидах - Хамар ханын хавтан угсрах - Ус тусгаарлагч хийх
9	Дүүжин тааз угсрах	<ul style="list-style-type: none"> - Таазны хэмжээ авах - Дүүжин таазны каркасыг зангидах - Дуу тусгаарлалт хийх - Таазны хавтанг угсрах - Таазны хүрээ угсрах
10	Шалны хийц угсрах	<ul style="list-style-type: none"> - Шалны талбайг хэмжих - Шалны гадаргуун тэгшилгээ хийх - Шалны дайг угсрах - Уур ус тусгаарлалт хийх - Шалны хавтан угсрах
11	Өөрийгөө хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн зэрэг ахиулах* - Шинэ техник тоног төхөөрөмж судлах* - Гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх* - Боловсролын түвшин ахиулах* - Шинэ материал технологи судлах* - Бусдаас туршлага судлах* - Компьютерийн ур чадвар дээшлүүлэх - Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх

7. Ажлын байр бусад албан тушаалын уялдаа холбоо

Хуурай хийцийн ажилтны бусад албан тушаалтантай ажиллах уялдаа холбоог дараах байдлаар дүрслэн харуулав.



Тухайн ажилтныг удирдах албан тушаал болон удирдуулан ажиллах ажилтныг босоо тэнхлэгээр харуулж байгаа бөгөөд энэ нь түүний өсч, дэвших боломжийг мөн илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, хуурай хийц угсрагч нь барилгын техникчийн удирдлага, хяналтан дор ажиллаж, туслах ажилтныг удирдан, хэвтээ тэнхлэгт байрлах ажилтнуудтай хамтран ажиллана.

8. Техникийн эсвэл мэргэжлийн боловсрол олгох байгууллага болон ажил олгогчийн мэдээлэл

Иргэн тухайн мэргэжлээр суралцах эсвэл ажил хайж байгаа тохиолдолд дараах мэдээлэлтэй танилцаж, сонголтоо хийх боломжтой.

Техникийн болон мэргэжлийн боловсрол олгох байгууллагуудын мэдээлэл	Ажил олгогч байгууллагуудын мэдээлэл
<p>Тухайн мэргэжлээр бэлтгэдэг мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага болон политехник коллежийн талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p>http://www.asc.mn</p>	<p>Тухайн мэргэжлээр ажилтан хайж байгаа байгууллагуудын талаарх мэдээллийг дараах вэб хуудаснаас авна уу.</p> <p>http://hudulmur-halamj.gov.mn/job/list</p>

9. Хуурай хийц угсрагч мэргэжлээр ажил мэргэжлийн лавлахыг боловсруулж, баталгаажуулсан төлөөлөл

Ажил мэргэжлийн лавлахын ДАКУМ шинжилгээг боловсруулахад оролцсон багийн гишүүд:

- | | |
|-------------------|--|
| 1. Ж.Гомбо | “Монгол дээвэр” ХХК-ийн хийцийн инженер |
| 2. Ц.Хишигбаяр | “Төгөлдөр өргөө констракшн” ХХК-ийн барилгын инженер |
| 3. Б.Амарсайхан | “Магма-Од” ХХК-ийн барилгын инженер |
| 4. Б.Мөнх-Эрдэнэ | “Кнауф-Гипс” ХХК-ийн сургалтын менежер |
| 5. Ж.Пүрэвсүх | “ОТЦОБ” ХХК-ийн хийцийн инженер |
| 6. С.Надмидцэрэн | “Топ фасад Монгол” ХХК-ийн барилгын инженер |
| 7. Б.Очирваань | “Байгууламж” ХХК-ийн бетон арматурчин |
| 8. О.Адъяа | “СНС” ХХК-ийн барилгын мужаан |
| 9. Н.Эрдэнэчулуун | “Жем констракшн” ХХК-ийн барилгын мужаан |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг баталгаажуулсан:

- | | |
|-----------------|--|
| 1. Д.Мижидсүрэн | Хот төлөвлөлтийн хүрээлэнгийн ерөнхий архитектор |
| 2. Г.Баясгалан | “Харандаа” ХХК-ийн ерөнхий инженер |
| 3. Ч.Цэрэнмядаг | “Си Эйч Си” ХХК-ийн захирал |
| 4. Г.Шоовдор | “Таконс” ХХК-ийн гүйцэтгэх захирал |
| 5. Х.Уртнасан | “Чинбат” ХХК-ийн барилгын инженер |
| 6. С.Баяр | “Жем констракшн” ХХК-ийн бригадын даамал |
| 7. Ц.Сүхбаатар | “СНС” ХХК-ийн ерөнхий инженер |
| 8. Д.Отгонбаяр | “ОТЦОБ” ХХК-ийн захирал |

Ажил мэргэжлийн лавлахыг боловсруулахад ашигласан ДАКУМ шинжилгээг хянасан барилгын салбарын экспертүүдийн төлөөлөл:

- | | |
|-----------------|--|
| 1. М.Батбаатар | Монголын Барилгачдын Холбооны Ерөнхийлөгч, Монгол Улсын зөвлөх инженер |
| 2. Ц.Сүхбаатар | “СНС” ХХК-ийн Ерөнхий инженер, Монгол Улсын зөвлөх инженер |
| 3. Б.Сүүндэлгэр | Сүүн мандал” ХХК-ийн захирал, Монгол Улсын зөвлөх инженер |

Ажил мэргэжлийн дүн шинжилгээний чиглүүлэгч:

- | | |
|------------------|--|
| 1. Д.Одбаяр | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, Монголын Барилгачдын Нэгдсэн холбооны мэргэжилтэн |
| 2. Т.Дэлхийцэцэг | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, Барилгын Политехник Коллежийн өрөг угсрагч мэргэжлийн багш |
| 3. Ч.Эрдэнэтуяа | ДАКУМ I+ зэргийн гэрчилгээт Сургагч багш, Өмнөговь аймгийн Политехник Коллежийн Сургалтын албаны дарга |

Ажил мэргэжлийн лавлахын загварыг боловсруулж, хянасан зөвлөхүүд:

- | | |
|----------------|---|
| 1. Д.Адилбиш | ХНХЯ-ны МБСБХЗГ-ын Ахлах мэргэжилтэн |
| 2. Ц.Ганчимэг | АХБ-ны ХЭУЧД төслийн ЧССҮ-ний мэргэжилтэн |
| 3. Д.Энхбаатар | ЧССҮ-ний Үндэсний зөвлөх |
| 4. Г.Батчимэг | ЧССҮ-ний Зөвлөх |

10. Хуурай хийц угсрагч мэргэжлийн үүрэг, ажилбарын зураглал (ДАКУМ шинжилгээ)

ҮҮРЭГ		АЖИЛБАР											
A	Ажлын байрыг бэлтгэх	A-1 Ажлын байрны зааварчилгаа авах ACA	A-2 Ажлын зурагтай танилцах BBA	A-3 Ажлын төлөвлөгөө гаргах BBA	A-4 Материалын орцыг тооцоолох BBA	A-5 Багаж тоног төхөөрөмжөө бэлтгэх BCA	A-6 Материалаа ангилж бэлтгэх CBA	A-7 Шат вандан угсрах ABA	A-8 Өргүүрийн механизм угсрах AAB				
		B-1 Хэмжилтийн тэмдэглэгээ хийх ACA	B-2 Налуу дээврийн бэлдэц угсрах BBB	B-3 Сараалж бүтээц угсрах AAB	B-4 Нээлхий бүтээц угсрах BBB	B-5 Дээврийн шалавч хийх CCB	B-6 Уур ус тусгаарлалт хийх BCB	B-7 Дээврийн хучлага угсрах AAA	B-8 Нээлхийний хучлага угсрах BBB	B-9 Нээлхийний хаалга угсрах BBB	B-10 Ус цуглуулагч угсрах BCB	B-11 Ус зайлуулагч угсрах BCB	B-12 Дээврийн газардуулга хийх ABC
C	Хавтгай дээвэр угсрах	C-1 Хавтгай дээврийн хэмжилт хийх ACA	C-2 Уур ус тусгаарлагч хийх BCB	C-3 Дулаалгын материал угсрах ABA	C-4 Дээврийн налуу гаргах AAB	C-5 Төмөр тор угсрах CBC	C-6 Дээврийн хавтан угсрах BAB	C-7 Парапетийн хавтан угсрах BAB	C-8 Завсар зай чигжих ABB	C-9 Хөрсжүүлэгч үе хийх BCB	C-10 Хуйлмал дээвэр наах AAA	C-11 Цацлага үе хийх CBB	C-12 Усны хоолой угсрах BCB
		D-1 Дүүргэлтийн ханын хэмжилт хийх AAA	D-2 Дүүргэлтийн бэлдэц бэлтгэх BBA	D-3 Суурийн гадаргууг бэлтгэх CBB	D-4 Гадна каркас зангидах AAA	D-5 Цонх хаалганы нээлхий гаргах BBB	D-6 Гадна уур ус тусгаарлалт хийх /амьсгалдаг/ BCB	D-7 Гадна дулаалга хийх BCA	D-8 Гадна ханын хавтан угсрах AAA	D-9 Дотор металл каркас зангидах BBA	D-10 Дотор дулаалга хийх BCB	D-11 Дотор уур ус тусгаарлалт хийх BCB	D-12 Дотор хавтан угсрах BBA
E	Шилэн фасад угсрах	E-1 Гадаргуугын хэмжилт хийх ABA	E-2 Гадаргуугын бэлдэц бэлтгэх ABA	E-3 Холбох каркас босгох AAA	E-4 Каркасын тэгшилгээ хийх ABA	E-5 Бэхэлгээ гагнуур хийх AAA	E-6 Галын хаалт хийх BAB	E-7 Дулаан тусгаарлалт хийх BBA	E-8 Шилэн хавтан угсрах AAA	E-9 Шилний заадас дулаалах AAB	E-10 Ус тусгаарлалт хийх ABA	E-11 Салхивчны хийц угсрах AAA	E-12 Гүйцэтгэлийн хяналт хийх ACA
		F-1 Ханын хэмжилт хийх AAA	F-2 Өнгөлгөөний бэлдэц бэлтгэх BBA	F-3 Бэхэлгээний каркас угсрах AAA	F-4 Бэхэлгээ төмөр гагнах /шаардлагатай/ ABB	F-5 Гадна дулаалга хийх AAA	F-6 Ус чийг тусгаарлалт хийх BBB	F-7 Өнгөлгөөний хавтан угсрах AAA	F-8 Амалгааны хавтан угсрах BBA	F-9 Заадасны чигжээс хийх ACA			
G	Гадна ханыг дулаалах	G-1 Дулаалах гадаргууг хэмжих BBA	G-2 Гадаргуугын тэгшилгээ хийх BBA	G-3 Гадаргууд хөрсжүүлэлт хийх BCA	G-4 Дулаалгын хавтан бэхлэх BBA	G-5 Дулаалгын хавтан наах ABA	G-6 Цавуу зуурмаг бэлтгэх CCA	G-7 Тортой шавардлага хийх AAA	G-8 Тэгшилгээ шавардлага хийх ABA	G-9 Амалгаа шавардлага хийх ABA	G-10 Өнгөлгөө шавардлага хийх CBA		
		H-1 Ханын хэмжилт тэмдэглэгээ хийх ABA	H-2 Тусгаарлах ханын бэлдэц бэлтгэх BCA	H-3 Чиглүүлэгч төмрөө шал таазанд бэхлэх BCA	H-4 /Босоо/ бэхэлгээ төмөр угсрах BCA	H-5 Нүүрийн хавтан угсрах BBA	H-6 Дуу дулаан тусгаарлалт хийх CCA	H-7 Эсрэг талын хавтан угсрах BBA	H-8 Хавтангийн чигжээс хийх ABA	H-9 Ус тусгаарлагч хийх CCB			
I	Дүүжин тааз угсрах	I-1 Таазны хэмжээ авах ABA	I-2 Таазны бэлдэц бэлтгэх BBA	I-3 Чиглүүлэгч зам бэхлэх BBA	I-4 Бэхэлгээний шилбийг байрлуулах AAA	I-5 Үндсэн каркасыг зангидах AAA	I-6 Дуу тусгаарлалт хийх BCC	I-7 Таазны хавтанг угсрах AAA	I-8 Хавтангийн чигжээс хийх ABA	I-9 Таазны хүрээ угсрах CBC			
		J-1 Шалны талбайг хэмжих ACA	J-2 Гадаргууд тэгшилгээ хийх BBA	J-3 Шалны дайг угсрах ABA	J-4 Шалны дулаалга хийх CCA	J-5 Уур ус тусгаарлалт хийх CBA	J-6 Шалны хавтан угсрах ABA	J-7 Шалны хвөө угсрах CCA	J-8 Завсрын чигжээс хийх CCA				
K	Өөрийгөө хөгжүүлэх	K-1 Мэргэжлийн зэрэг ахиулах BCC	K-2 Шинэ техник төхөөрөмж судлах ABC	K-3 Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх BCC	K-4 Боловсролын түвшин Ахиулах ABA	K-5 Шинэ материал технологи судлах ABA	K-6 Бусдаас туршлага судлах ABA	K-7 Компьютерийн ур чадвар дээшлүүлэх BCA	K-8 Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх ACA				

ТЭМДЭГЛЭЛ: Саарал өнгөтэй хэсэгт ажлын байран дээр ирэхээс өмнө сургалтын байгууллагаар олгох ажилбарыг заасан бөгөөд үүнийг сургалтын хөтөлбөрийн агуулгад заавал тусгана. Цагаан толгойн гурван үсгийн дарааллаар чухал, хүнд, давтамжийн үзүүлэлтүүдийн харьцангуй түвшинг илэрхийлдэг. Ингэхдээ эхний үсэг нь чухлын зэргийг (А-маш чухал, В-чухал, С-чухал биш), хоёр дахь үсэг нь ажилбарын хүндрэлийн түвшинг (А-маш хүнд, В-хүнд, С-хүнд биш), гурав дахь үсэг нь ажилбарыг гүйцэтгэх давтамжийг (А-байнга, В-заримдаа, С-ховор) илэрхийлнэ. Жишээлбэл: Ажилбарыг ABC гэж тэмдэглэсэн бол тухайн ажилбар нь маш чухал, хүнд, ховор гүйцэтгэдэг ажилбар гэсэн утгатай.